



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.08.30 № 021/785  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН Т  
ХАМГААЛЛЫН ЯМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтооолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулгыг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт ..... хуудастай

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН  
ГАЗРЫН ДАРГА Б.ТАНХУЯГ

9024070103 СТС4665 9031739 My doc.DAMG A-5 /24.09/ sar

1524082471

# БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

## Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны эхний 8 сарын байдлаарх хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн хийлээ.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Нийгмийн даатгалын чиглэлээр 1 зорилт бүхий 5 арга хэмжээ тусгагдсан байна.

Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэлийн “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ;
- Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно;
- Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ;
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно;
- Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно;

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг харуулбал:

Зорилт, үйл ажиллагаа ны дугаар	Зорилт	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо				
		100	90	70	80	Хэрэгжилт /Хувиар/
3.1.1.	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1				100
3.1.2.	Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно		1			90
3.1.5.	Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулж, Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ.		1			90
3.1.6.	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно			1		70
3.1.8.	Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно.	1				100
<b>Нийт</b>		<b>2</b>	<b>2</b>	<b>1</b>		<b>90</b>

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгээр:

- *Үр дүнтэй* буюу шалгуур үзүүлэлт зорилtot түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн 100 хувьтай 2 арга хэмжээ;
- *“Тодорхой үр дүнд хүрсэн”*:
  - ✓ Зорилт нь арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхэлсэн 90 хувьтай 2 арга хэмжээ;
  - ✓ *Үр дүнг нэмэгдүүлэх* шаардлагатай үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай гүйцэтгэл нь 70 хувьтай 1 арга хэмжээ байна.

### Дөрөв. Дүгнэлт

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журам”-ын дагуу бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2024 оны эхний 8 сарын байдлаар 90 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг хавсаргав.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР

АЛСЫН ХАРАА 2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	ARYAAP ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТ АРГА	Үндэслэлж байгаа бодлогын баримт бичиг	<b>Гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)</b>  <b>Зорилтот түвшин</b>
1	3.1.1.	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг даатгалд даатгуулах хөтөлбөр хэрэгжүүлэх	<p>Энэхүү зорилтын хүрээнд Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаа Нийтийн даатгалын өрөнхий хуульд дараах заалтууд тусгагдсан. Үнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21 дэх хэсэгт гурав хүртэлх наасны хүүхдээ асарч байгаа эх сайн дурын даатгуулбал түний тодорхойлсон орлогын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох орлогоос тэтгэвэр, тэтгээнийн даатгалын шимтэгийн 50 хувийг тэтгээмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцахаар;</li> <li>- Хуулийн 21.22 дахь хэсэгт эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх наасны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлгөмрөр эрхлээгүй эх, эсхүл эцэг сайн дурын даатгалд даатгуулбал түний тодорхойлсон орлогын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох орлогоос тэтгэврийн даатгалын шимтэгийн 50 хувийг улсын төсвөөс хариуцахаар;</li> <li>- Хуулийн 21.23 дахь хэсэгт малчин, туслах малчин сайн дурын даатгалд даатгуулбал түний тодорхойлсон орлогын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох орлогоос тэтгэвэр, тэтгээмжийн даатгалын шимтэгийн 50 хувийг улсын төсвөөс хариуцахаар тус тус заасан.</li> </ul> <p>Сайн дурын даатгалд 2024 оны эхийн хагас жилийн байдлаар 0-3 наасны хүүхдээ асарч байгаа сайн дурын даатгалд даатгууллагч 3.4. мянган эхийн төлөх шимтэгийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох хэсгийн 50 хувь буюу 0.5 тэрбум төгрөгийг тэтгээмжийн даатгалын сангаас, 2.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, нийт</p>

		<p>2.6 Тэрбум төгрөг, хөтжийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа сайн дурын даатгалд даатгуулагч 2.4 мянган эх /эцэг/-ийн хөдөлмөрийн хөлслний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлд 3.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс тус тус хариуцан төлж, эдгээр иргэдийг нийгмийн даатгалд хамруулсан.</p> <p>Мөн Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “2024 оны нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай” А/61 дүгээр тушаалыг батлуулж, сайн дурын даатгалд 2024 онд 34.7 мянган даатгуулагчийг, үннээс 7.5 мянган малчныг шинээр хамруулах төлөвлөгөөг аймаг, дуургийн Нийгмийн даатгалын газрын дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар 25.4 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр, үннээс 8.7 мянган малчныг сайн дурын даатгалд хамруулсан дундтай байна.</p>	
	<p>Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн нариуулга/-ийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хурапдаанаар /Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан евчиний тэтгэвэр. тэтгэмж, төлбөрийн тухай хууль/ баталж, нийгмийн даатгалын байгууллага 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна.</p> <p>Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар 69 дүрэм, журам, заавар шинээр батлуулахаас 2024 оны эхний 8 сард 59 дүрэм, журам, зааврыг батлуулсан байна. Үннээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар 10 дүрэм, журам, заавар батлуулахаас 8 дүрэм, журам, зааврыг баталж хууль, дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлэхтэй холбоотой 10 зөвлөмж, 4 чиглэл, 11 шийдвэрийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 1;</li> </ul>	90	
2	3.1.2.		

		<ul style="list-style-type: none"> <li>- Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой 10;</li> <li>- Шимтгэлтэй холбоотой 10;</li> <li>- Сайн дурын даатгалтай холбоотой 1;</li> <li>- Маягтын загвар, аргачлалтай холбоотой 1;</li> <li>- Нэрийн данстай холбоотой 1;</li> </ul>	
	Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулж, нутгийн захиргааны байгууллагатай хамтран ёрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлагчдийг нийгмийн даатганд даатгуулах чилэлтээр сургалт, сурталчилгаа хийнэ.	<p>1. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 оны 01 дугээр сараас эхэн Иргэний цахим систем, Ажил олгогчийн цахим систем, Нийтмийн даатгалын цахим системүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж эдгэр системүүдийг ашиглан 24/7 цагийн горимоор нийгмийн даатгалын үйлчилгээг узүүлж байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2024 оны 01 дугээр сард хөдөлмөрийн чадвар тур алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж, сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, шинээр тэтгэвэр тогтоолгох үйлчилгээг нэвтрүүлсэн. Эдгээр Үйлчилгээг авах нэвтрүүлснээр эхний 8 сарын байдлаар нийтмийн даатгалын үйлчилгээг авах нийт 347.5 мянган хүсэлт ирснээс 219.1 мянга нь цахимаар илгээж, 128.4 мянга нь нийтмийн даатгалын байгууллагад биеэр ирж хүсэлтээ өгсөн байна. Үнд:</li> <li>• Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх нийт 125.4 мянган хүсэлтээс 13.4 мянган хүсэлтийг иргэний цахим системээр, 112.0 мянган хүсэлтийг нийтмийн даатгалын цахим системээр хүлээн авч тооцоолон 99.3 хувийг шийдвэрлэсэн байна;</li> <li>• Хөдөлмөрийн чадвар тур алдсаны тэтгэмж авах хүсэлт, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж авах хүсэлт, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох нийт 161.6 мянган хүсэлтээс 115.0 мянган хүсэлтийг иргэний цахим системээр, 46.6 мянган хүсэлтийг нийтмийн даатгалын цахим системээр хүлээн авч тооцоолон 92.4 хувийг шийдвэрлэсэн байна.</li> <li>• Өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 59.4 мянган иргэний хүсэлтийг хүлээн авч нийтмийн даатгалын цахим системээр үйлчилгээ үзүүлж тооцоолон 92.8 хувийг шийдвэрлэсэн байна.</li> </ul>	90
3	3.1.5.		

► Давхардсан тоогоор нийтдээ 4.2 сая тэтгэвэр авагчийн тэтгэвэр олголтыг цаг хугацаанд нь хийсэн байна.

► **Ажил олгогчийн тайланицын цахим систем:**

- 2024 оны 02 дугаар сарын 15-ны эхэн ажил олгогчийн шимтэгийн тайланг хүлээн авах системийг нэвтрүүлсэн. Үүний үр дунд давхардсан тоогор 373.2 мянган ажил олгогч, 5.7 сая гаруй албан журнаар дааттулагчийн 1-7 дугаар саруудын НДШ-ийн тайланг илгээсэн байна.
- Ажил олгогчоос илгээсэн 1-7 дугаар сарын НДШ-ийн тайланг нийгмийн даатгалын байцаагч хүлээн авч шалгасны дараа систем автоматаар баталгаажуулах үйлдэл хийж байгаа бөгөөд нийт илгээсэн тайлангийн 99.4 хувийг баталгаажуулсан байна.
- Тухайн сард үйл ажиллагаа эрхлээгүй ажил олгогч X /икс/ тайлан илгээх боломжийг бурдудулсэн.

► **Нийгмийн даатгалын шимтэгэл төлөлтийн лавлагаа:**

- 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс дааттулагч, ажил олгогч нийгмийн даатгалын шимтэгэл төлөлтийн лавлагаагаа цахимаар авах үйлчилгээг нэвтрүүлсэн. Үүний үр дунд цахим системээс нийгмийн даатгалын шимтэгэл төлөлтийн 89.2 гаруй мянган QR кодтой лавлагааг авсан байна.

► **Нийгмийн даатгал аппликашион:**

- 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс иргэд дааттулагчид зориулсан "Нийгмийн даатгал" аппликацийн хувилбарыг шинэчлэн боловсруулан нэвтрүүлсэн. Уг аппликацийн ээр сайн дураар дааттуулах 4 төрлийн гэрээ байгуулах хүсэлт илгээх, сайн дурын даатгалын шимтэгэл төлөх, QR кодтой нийгмийн даатгалын шимтэгэл төлөлтийн лавлагаа авах, мөн тэтгэврийн мөнгөн хурийн шимтэгэл тооцоолоп болон нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл харах боломжтой юм.

	<p>➤ <b>Өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд хуульд заасан болзой нөхцөлийг хангасан түүний нөхөр, эхнэрийн өндөр насны тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэх боломжийг бурдуулсан бөгөөд одоогийн байдлаар нийтдээ 1,248 тэтгэвэр авагч энэхүү үйлчилгээнд хамрагдсан байна.</li> </ul> <p>➤ <b>Тэтгэврийн нөөц санд байршуулах мөнгөжүүлсэн орлого:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу 2024 онд тэтгэврийн даатгалын санд шимтгэл ногдуулж, төлөлт нь хийгдсэн албан журмаар болон сайн дураар дааттуулагчийн сарын цалин хөлс, түнтэй адилтгах орлогоос нийтдээ 2 хувиар тооцон тэтгэврийн нөөц санд байршуулах мөнгөжүүлсэн орлогын тооцооплыг хийсэн. 2024 оны 08 дугаар сарын байдлаар мөнгөжүүлэхэд бэлэн 974.0 мянган дааттуулагчийн 212.3 тэрбум төгрөг байна. Мөн тэтгэврийн нөөц санд байршуулах мөнгөжүүлэхээр тооцсон орлогыг Иргэний цахим систем болон Нийгмийн даатгал апликешиинээр харуулах боломжийг бурдуулсэн</li> </ul>
	<p>Түүнчлэн иргэд дааттуулагч, ажил олготгийн нийгмийн даатгалын шимтэлийн лавлагаяа, тодорхойлолт болон тэтгэвэр тогтоолтын хуудсыг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-гаас авах боломжийг бурдуулсэн. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын гаржиллагаа багасч, ажлын ачаапал тэнцвэржиж, иргэдэд зөвлөгөө өгөх, үйлчлэх ажилдаа илүү цаг зарцуулах боломж бурдэнэ.</p> <p>2. Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, хууль тottoомжийг сурталчлах зорилгоор ажил олготгч, иргэд дааттуулагчид чиглэсэн 1,012 удаагийн танхмын болон цахим сургалтад 4,694 аж ахуйн нэгжийн 49,013 иргэд, дааттуулагчийг хамруулсан.</p> <p>Мөн салбарын хэмжээнд 85 удаагийн явуулын үйлчилгээнд 52,721 иргэд дааттуулагч, 71 удаагийн нээлттэй хаалтаны өдөрлөгт 22,885 нийт 156 удаагийн</p>

			арга Хэмжээнд 75,606 иргэд даатуулагчад нийтмийн даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
4	3.1.6.	Нийтмийн даатгалын хөрөнгө бодлогыг тодорхойлно	<p>Нийтмийн даатгалын ерөнхий хуульд нийтмийн даатгалын сангийн хөрөнгийн удирдлагыг сайжруулахтай холбоотой "Нийтмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага" гэсэн 13 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2024 оны "Засгийн газар болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай" 14 дүгээр тогтоолоор 2024 онд сангийн чөлөөт Улдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 300.0 тэрбум төгрөгөөр баталсан. Үний дагуу 2024 оны 02 дугаар сард Хөдөлмөр, нийтмийн хамгааллын яам болон Сангийн яаманд Засгийн газрын бонд худалдаж авах хүсэлт хүргүүлсэн.</li> <li>- Мен 2024 оны 06 дугаар сард Төрийн сангийн нэгдсэн дансанд байришиж буй нийтмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн Улдэгдэлд хүү тооцуулах, Нийтмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах талаар ХНХЯ болон Сангийн яаманд санал хүргүүлсэн.</li> <li>- Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохицтой харьцааны шалтуур үзүүлэлтийг хангасан, банкны системд нөлөө бүхий 5 арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн саналыг НДҮЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр 2024 оны 01/1765 дугаар албан бичгээр НДҮЗ-ийн ажлын албандаа хүргүүлсэн.</li> <li>- НДҮЗ-ийн 2023 оны "Нийтмийн даатгалын сангийн чөлөөт Улдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2024 оны хүүгийн доод хэмжээг батлах тухай" 22 дугаар тогтоолоор арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2024 оны хүүгийн доод хэмжээг 13.07 хувиар баталсан.</li> <li>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор "Нийтмийн даатгалын сангийн чөлөөт Улдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-ыг баталсан.</li> </ul> <p>Нийтмийн даатгалын багц хувьтой хэрэгжсэнээр Нийтмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэлийн 2 дугаар үе шатанд Нийтмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх боломжтой байна.</p>

5	3.1.8.	Тэтгэврийн даатгалын хагас тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 онос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлогыг "Тэтгэврийн нөөц санг бурдудлаад, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх" гэж заасны дагуу тэтгэврийн даатгуулагчийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд байршуулж байна.	Нийтгийн даатгалын ерөнхий хуулийн 29 дугээр зүйлд "Тэтгэврийн нөөц санг бурдудлаад, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх", 29 дугээр зүйлийн 29.3.1-д "тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олготчийн 1.0. даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлогыг "Тэтгэврийн нөөц санг бурдудлаад, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх" гэж заасны дагуу тэтгэврийн даатгуулагчийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд байршуулж байна.
			Тус санд 2024 оны 8 сарын 11-ний өдрийн байдлаар 177.0 тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд байршуулаад байна.